

**ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

**Аудитын код: САГ-2018/16/СТА-ТТЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 260512 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Жавхлан  
Аудитор Ж.Болормаа

Утас: 261628 Цахим хаяг: javkhlан@audit.gov.mn  
bolormaaj@audit.gov.mn

Улаанбаатар хот



## АГУУЛГА

---

1	Аудитын гэрчилгээ .....	1
2	Аудитын тайлан .....	3
2.1	Оршил .....	3
2.2	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл .....	3
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	4
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	4
2.5	Дотоод хяналт .....	5
2.6	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар .....	5
2.7	Шилэн дансны мэдээлэл.....	6
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар .....	6
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....	6
2.9.1	Цалингийн суутгалын бүртгэлийн талаар.....	6
2.9.2	Авлагын талаар.....	6
2.9.3	Үндсэн хөрөнгийн шилжилт хөдөлгөөний талаар.....	7
2.9.4	Үйл ажиллагааны нэмэлт орлогын талаар.....	7
2.9.5	Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн алдаа, зөрчлийн талаар.....	7
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	8
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	8
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	9
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
2.16	Аудитын үр өгөөж .....	9
3	Менежментийн захидал .....	10
3.1	Авлагын талаар .....	11
3.2	Дотоод хяналтын талаар .....	11
3.3	Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүгнэлтийн талаар .....	12
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	13
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан .....	13
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан .....	13
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан .....	14
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан.....	15
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	16

## 1 Аудитын гэрчилгээ



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2018.03.23 № 01/202  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА Б.НЯМДАВАА ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ

## 2 Аудитын тайлан

### 2.1 Оршил

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Б.Нямдаваа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 2.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.


Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 03 дугаар сарын 05-наас 03 дугаар сарын 25-ны хооронд хийж, аудитын тайланг Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Жавхлан, аудитор Ж.Болормаа нар гүйцэтгэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/221 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.





## 2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Тус байгууллага нь хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, нийгмийн халамжийн үйл ажиллагааны төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийг ажилтай, орлоготой болгох, ядуурлыг бууруулах, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг чанаржуулах, Монгол хүний амьдралын чанарыг сайжруулах эрхэм зорилго дэвшүүлж ажилладаг.

Дээрх зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно” гэж заасны дагуу тус газрын дарга нь төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2017 оны төсвийг Сангийн яамны Төрийн сангаас олгож, хяналт тавьж ажилласан байна.

Тус газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан болно

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. Тухайлбал,

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай
- Нийгмийн халамжийн тухай
- Ахмад настны нийгмийн хамгааллын тухай
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох заавар, журмууд байна.

## 2.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН


Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 7 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 37 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим, сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.



Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг ашигладаг боловч шинэчлэл хийгдээгүй байна.

Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах, тайлан гаргах ажиллагааг санхүүгийн “Acolous” програмаар, нэгтгэлийг Э-тайлангаар гүйцэтгэсэн байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

## 2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хяналт мониторингийн газрын 2017 оны ажлын төлөвлөгөөнд 3 чиглэлээр дотоод аудит хийхээр төлөвлөсөн боловч 21 аймаг, 9 дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт мониторинг хийхээр төлөвлөсөн ажил хийгдээгүй байна.

Тайлант онд хийгдсэн дотоод аудитын хяналт шалгалтаар нийт 3.7 сая төгрөгийн 1 албан шаардлага, 120.1 сая төгрөгийн 31 төлбөрийн акт тавигдсан байна.

Акт албан шаардлагын биелэлтийг хянаж үзэхэд 4.3 сая төгрөгийн акт хэрэгжиж, 80.4 сая төгрөгийн акт шүүхийн байгууллагад шилжсэн, 35.4 сая төгрөгийн акт хэрэгжээгүй байгаа нь актын биелэлт хангалтгүй байна.


Дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон боловч дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөтэй” байна.

## 2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын зүйл ангиар хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Тус байгууллагын 2017 оны төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулан хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	20,736.6	20,376.3	(360.2)
Урсгал зардал	20,736.6	20,376.3	(360.2)
Бараа, ажил үйлчилгээний зардал	19,945.2	19,624.1	(321,1)
Урсгал шилжүүлэг	791,3	752,2	(39.1)
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	20,736.6	20,376.3	(360.2)



Тайлант онд 20,736.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас Улсын төсвөөс 19,511.2 сая төгрөг, өөрийн орлогоос 1,588.6 сая төгрөг нийт 21,099.9 сая төгрөгийн санхүүжилт авч 20,367.4 сая төгрөгийг зарцуулж үлдэгдэл 732.5 сая төгрөгийг Төрийн санд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 6,089.5 сая төгрөгийн орлого, 5,760.2 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 329.3 сая төгрөгийг Төрийн санд төвлөрүүлсэн ба 203.7 сая төгрөгийг авлагаар бүртгэсэн байна.

Улсын төсвийн хөрөнгөөр тус байгууллагын харьяа 6 газарт нийт 500.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлын эрх шилжиж ирснээс гүйцэтгэлээр 489.9 сая төгрөг зарцуулсан байна.

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангаарх мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 14.8 сая төгрөг нь Орхон, Дундговь аймгууд болон Хан-Уул дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дэргэдэх Ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны 3 дугаар тогтоолоор Яамдын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотой тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн эхний үлдэгдэл нь Хөдөлмөрийн яам, Нийгмийн хамгааллын яамны эхлэлтийн балансын дүнг тайлагнасан байна.

## **2.7 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 5,6,7 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) веб сайтад 3 төрлийн мэдээллийг оруулсан байна.

Цахим хуудсанд төсөв/гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт, бусад гэсэн мэдээллийн ангиллаар төрийн сан дахь харилцах дансны гүйлгээ, байгууллагын даргын тушаал шийдвэр, гэрээ зэрэг холбогдох мэдээллийг байршуулсан байна.

## **2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 44 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 37 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

## **2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл**

### **2.9.1 Цалингийн суутгалын бүртгэлийн талаар**

Цалингаас суутгасан Хувь хүний орлогын албан татварын орлогын илүү төлөлт 3.5 сая төгрөгийг харьяалагдах Татварын хэлтэстэй тооцоо нийлж баталгаажуулаагүй Өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх үеийн үр дүнд бүртгэж үр дүнг бууруулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

### **2.9.2 Авлагын талаар**





Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын санхүүгийн тайланд 209.8 сая төгрөгийн авлага тайлагнаснаас Сангийн яамнаас авах 7.6 сая төгрөгийн авлага нь 2010 онд үүссэн он удаан жил болсон авлага байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өгөх

### 2.9.3 Үндсэн хөрөнгийн шилжилт хөдөлгөөний талаар

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хөрөнгийн дансанд бүртгэлтэй байсан автотээврийн хэрэгсэл 57.7 сая, тавилга эд хогшил 21.8 сая, машин тоног төхөөрөмж 35.1 сая, бараа материал 5.1 сая төгрөг нийт 119.7 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн боловч БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв бүртгэж аваагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

### 2.9.4 Үйл ажиллагааны нэмэлт орлогын талаар

Тайлант онд үйл ажиллагааны орлого 962.5 сая төгрөг тайлагнаснаас 600.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж 343.2 сая төгрөгийн давсан орлогыг хөрөнгө оруулалт, их засвар болон ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулсан байна.

Давсан орлогын 40 хувь буюу 137.3 сая төгрөгийг хөрөнгө оруулалтад, 60 хувь буюу 205.9 сая төгрөгийг урамшуулал хэлбэрээр олгосон байна.

Үүнээс, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ажилтнуудад нийт 104.7 сая төгрөгийн урамшуулал хуваарилж олгосон нь Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.4-д “Энэ хуулийн 46.3.2, 46.3.3-т заасан урамшууллыг хуваарилах асуудлыг байгууллагын нийт ажилтныг оролцуулсан хамт олны хурлаар хэлэлцэн, шийдвэрлэх бөгөөд хамт олны хурлын тэмдэглэл болон шийдвэрийг үндэслэн тухайн шатны төрийн сан зарцуулах эрх олгоно” гэж заасантай нийцэхгүй байна.


Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

### 2.9.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн алдаа, зөрчлийн талаар

Санхүүгийн нэгтгэсэн тайланд 36 тайлан нэгтгэгдсэнээс 2 тайлан түүвэрт, 1 тайланд итгэл үзүүлж, 28 тайлан Зөрчилгүй, Багахангай болон Баянзүрх дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдийн санхүүгийн тайлан Хязгаарлалттай дүгнэлт авч, Орхон, Дундговь аймгуудын болон Хан-Уул дүүргийн Ахмадын сангийн тайлангууд аудит хийгдээгүй нэгтгэгдсэн байна.

Орон нутгийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 318.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 176.0 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 5.1 сая төгрөгийн 4 акт, 31.4 сая төгрөгийн 3 албан шаардлага, 105.6 сая төгрөгийн 52 зөвлөмж өгөгдсөн байна. Үүнд,

- Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Ховд аймгуудын Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрууд тэтгэмж, урамшуулал илүү олгосон зэрэг зөрчилд 5.1 сая төгрөгийн төлбөрийн акт,
- Говь-Алтай, Төв аймгуудын Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрууд тайлант онд өр үүсгэсэн, шатахууны тооцоо алдаатай хийсэн, өөрийн орлогыг Төрийн санд өдөрт нь тушаагаагүй зэрэг зөрчилд 31.4 сая төгрөгийн албан шаардлага өгсөн байна.



Санхүүгийн тайланд нэгтгэгдсэн 11 тайланд Хараат бус аудитын компани, 21 тайланд Аймгууд дахь Төрийн аудитын байгууллага аудит хийж дүгнэлт гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өгөх

## 2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар анхаарал татахуйц дараах асуудал илэрсэн байна. Үүнд,

- Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны ажилд зориулан Хүнс тэжээл, нийгмийн халамжийн төслөөс 610.5 сая төгрөгийн санхүүжилт авснаас 240.0 сая төгрөгөөр Нийгмийн хамгаалал ба өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны сэтгүүл хэвлүүлсэн боловч тус сэтгүүл нь санхүүжилтийн зорилготой нийцээгүй байна.
- Байгууллагын хөрөнгөнд 7 автомашин бүртгэлтэй байгаагаас дарга, 2 дэд даргын үйлчилгээнд 4 автомашин, Тамгын газар, санхүүгийн хэлтсийн үйлчилгээнд 2 автомашин ашигладаг ба 1 тээврийн хэрэгсэл ашиглагдах боломжгүй олон жил болсон байна.

Тайлант хугацаанд 3 тээврийн хэрэгсэл нэмэгдэж, 5 тээврийн хэрэгсэл балансаас балансад шилжсэний дотор ХНХЯ-нд 2 автомашин шилжүүлэн өгч 1 автомашин шилжүүлж авсан байна.

Дээрх 7 автомашины 3 нь том оврын бензин, тосны зарцуулалт ихтэй Ланд 200 маркийн автомашинууд байгаа нь төсвийн байгууллагын шатахууны болон засвар үйлчилгээний зардлыг өсгөж байна.

## 2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын складанд байгаа ашиглагдахгүй 799.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нь 2016 онд Нийгмийн халамжийн ерөнхий газар болон Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний үндэсний төв нийлснээс бий болсон хөрөнгө бөгөөд цаашид хэрхэн ашиглах нь тодорхой бус байгааг дараагийн аудитаар дахин хянах шаардлагатай байна.


## 2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 586.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 296.2 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 5.1 сая төгрөгийн 4 акт, 136.1 сая төгрөгийн 4 албан шаардлага, 148.6 сая төгрөгийн 52 зөвлөмж өгсөн байна.

## 2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

2016 оны санхүүгийн тайланд УАГ аудит хийж 5 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 86 хувьтай байна. Зөвлөмжийн хэрэгжилт бүрэн хэрэгжээгүй шалтгааныг тодруулбал харьяа байгууллагуудад өгсөн хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх зэрэг тухайн байгууллагаас шалтгаалахгүй зөвлөмжүүд бүрэн хэрэгжээгүй байна.

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 1/1047 дугаартай албан бичгээр УАГ-т ирүүлсэн байна.



## **2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитын төлөвлөх ба гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг АОУС 320-ын дагуу тодорхойлсон болно.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн материаллаг байдлын түвшинг гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцож санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт орлогын 1 хувь буюу 328.7 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь болон хувийг төлөвлөснөөс өөрчлөөгүй боловч материаллаг байдлын түвшин төлөвлөснөөс багассан тул санхүүгийн тайлангуудын орлого зардлын нэгтгэл болон хоорондын гүйлгээний устгах бичилтийг тулган шалгах нэмэлт горим, сорил хэрэгжүүлэв.

## **2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ**

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн дүн, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.

## **2.16 Аудитын үр өгөөж**

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас харьяа байгууллагад шилжүүлсэн 119.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлж авсан байгууллага нь данс бүртгэлдээ тусгаагүй байсныг аудитын явцад залруулж санхүүгийн үр өгөөж бий болгов.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



### 3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим чиглэгдсэн.

Энэ нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн албаны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

**Менежментийн захидалд дурдсан асуудал цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар нэгтгэн харуулав.**

**Дараах зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.**



**3.1 АВЛАГЫН ТАЛААР**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**ҮАГ-ын ажиглалт**

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын санхүүгийн тайланд 209.8 сая төгрөгийн авлага тайлагнаснаас Сангийн яамнаас авах 7.6 сая төгрөгийн авлага нь 2010 онд үүссэн он удаан жил болсон авлага байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйл и йн 20.2.6-д “ ... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг баримталж ажиллах

Санхүүгийн тайлангийн дуусвар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангах

**Эрсдэлүүд**

Хуулийн заалт хэрэгжихгүй байх, эзэн холбогдогч тодорхойгүй, найдваргүй авлага нэмэгдэх

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлээр танилцуулсан энэхүү алдаа, зөрчлийг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

**3.2 ДОТООД ХЯНАЛТЫН ТАЛААР**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**ҮАГ-ын ажиглалт**

Хяналт мониторингийн газрын 2017 оны ажлын төлөвлөгөөнд 3 чиглэлээр дотоод аудит хийхээр төлөвлөсөн боловч 21 аймаг, 9 дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт мониторинг хийхээр төлөвлөсөн ажил хийгдээгүй бөгөөд нийт 120.1 сая төгрөгийн 31 төлбөрийн акт тогтоосноос 4.3 сая төгрөгийн акт хэрэгжиж, 80.4 сая төгрөгийн акт шүүхийн байгууллагад шилжсэн, 35.4 сая төгрөгийн акт хэрэгжээгүй байгаа нь актын биелэлт хангалтгүй байна.

**ҮАГ-ын зөвлөмж**


Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-д “дотоод аудит гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг ойлгоно” гэж заасны дагуу Хяналт мониторингийн газрын ажлыг бодитой төлөвлөж гүйцэтгэлийг хангуулах

**Эрсдэлүүд**

Хуулийн заалт хэрэгжихгүй байх, дотоод хяналт сулрах

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлээр танилцуулсан энэхүү алдаа, зөрчлийг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.





**3.3 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТИЙН ТАЛААР**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**ҮАГ-ын ажиглалт**

Санхүүгийн нэгтгэсэн тайланд 35 тайлан нэгтгэгдсэнээс Багахангай болон Баянзүрх дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдийн санхүүгийн тайлан Хязгаарлалттай дүгнэлт авсан байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх” гэсэн зарчмыг хэрэгжүүлж ажиллах

**Эрсдэлүүд**

Санхүүгийн сахилга хариуцлага алдагдах, төсвийн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт сулрах

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлээр танилцуулсан энэхүү алдаа, зөрчлийг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

#### 4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

##### 4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	/мянган төгрөг/	
		2016оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,540,525.6	1,764,060.2
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	8,944.2	14,838.6
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	336,131.6	609,223.7
УРЬДЧИЛГАА	7а, 7б	9,846.8	1,851.4
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	1,185,602.9	1,138,146.5
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		27,714,966.6	26,435,686.3
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	27,714,966.6	26,435,686.3
Биет хөрөнгө		27,248,461.6	26,121,121.6
Биет бус хөрөнгө	13	466,505.0	314,564.7
Бусад хөрөнгө /ТӨҮГ/		0.0	0.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		29,255,492.2	28,199,746.5
НИЙТ ӨР ТӨЛБӨР		20,516.5	28,003.1
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	20,516.5	28,003.1
Өглөг	17а, 17б	20,516.5	28,003.1
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		29,234,975.7	28,171,743.4
Засгийн газрын хувь оролцоо		29,234,975.7	28,171,743.4
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		9,138,848.1	9,997,522.3
Хуримтлагдсан үр дүн		18,761,434.4	16,841,098.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,334,693.3	1,333,122.4
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		29,255,492.2	28,199,746.5


##### 4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	/мянган төгрөг/	
		2016оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		41,214,695.9	32,873,876.6
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	28,983,634.6	7,385,832.4
Нийтлэг татварын бус орлого		28,983,634.6	7,385,832.4
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		12,231,061.3	25,488,044.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	13,697,506.6	31,763,668.7
УРСГАЛ ЗАРДАЛ		13,694,619.4	31,763,668.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		10,706,644.7	28,050,066.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		7,289,053.2	14,390,851.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		749,586.7	1,573,670.5

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		656,317.8	1,441,506.5
Хангамж, бараа материалын зардал		451,267.9	2,968,638.3
Нормативт зардал		174,206.9	640,158.1
Эд хогшил, урсгал засварын зардал		89,178.8	242,578.0
Томилолт, зочны зардал		70,606.9	485,327.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		471,132.4	2,103,620.9
Бараа үйлчилгээний бусад зардал		755,293.9	4,202,313.9
ХҮҮ		0.0	0.0
ТАТААС		0.0	7,952.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,987,974.6	3,706,154.2
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>2,887.2</b>	<b>0.0</b>
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		27,517,189.3	1,110,207.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		1,484,136.4	126,777.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		31,350.6	2,305,427.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		28,969,975.1	-1,068,442.1

#### 4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Цөөнхийн хувь оролцоо	/мянган төгрөг/
			Нийт цэвэр хөрөнгө/өмч
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.0	0.0	0.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	265,000.6	0.0	265,000.6
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	265,000.6	0.0	265,000.6
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	28,969,975.1	0.0	28,969,975.1
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	29,234,975.7	0.0	29,234,975.7
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	29,234,975.7	0.0	29,234,975.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-136,247.9	0.0	-136,247.9
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,098,727.7	0.0	29,098,727.8
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-724.1	0.0	-724.1
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-846.7	0.0	-846.7
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	-925,413.5	0.0	-925,413.5




2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	28,171,743.4	0.0	28,171,743.4
---------------------------------------	--------------	-----	--------------

#### 4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан


/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	2016оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	13,516,423.5	28,503,226.3
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,227,324.2	2,856,317.8
Нийтлэг татварын бус орлого	1,227,324.2	2,856,317.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	12,289,099.3	25,646,908.5
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,478,354.6	28,374,793.7
УРСГАЛ ЗАРДАЛ	13,478,354.6	28,374,793.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,291,097.1	24,512,552.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,239,807.1	14,257,643.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	748,610.4	1,559,347.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	707,359.5	1,422,075.4
Хангамж, бараа материалын зардал	461,199.7	2,059,354.6
Нормативт зардал	202,565.0	618,085.8
Эд хогшил, урсгал засварын зардал	109,851.4	271,600.5
Томилолт, зочны зардал	72,010.7	492,256.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	567,140.4	2,288,555.2
Бараа үйлчилгээний бусад зардал	182,552.9	1,543,633.1
ТАТААС	0.0	7,952.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,187,257.5	3,854,289.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	38,068.9	128,432.6
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	0.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	29,124.7	122,563.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,124.7	122,563.9
Дотоод эх үүсвэрээр	29,124.7	122,563.9
Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-29,124.7	-122,563.9
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	25.7
Бусад эх үүсвэр	0.0	25.7
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	0.0
ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.0	0.0
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	0.0
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	8,944.2	5,894.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,944.2	8,944.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,944.2	14,838.6



#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	/төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,736,604,000.0	20,376,355,466.0	360,248,534.0	98.3
УРСГАЛ ЗАРДАЛ	20,736,604,000.0	20,376,355,466.0	360,248,534.0	98.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,945,270,100.0	19,624,139,742.6	321,130,357.4	98.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,226,355,300.0	14,113,997,163.2	112,358,136.8	99.2
Үндсэн цалин	11,197,141,000.0	11,302,298,974.7	(105,157,974.7)	100.9
Нэмэгдэл	2,099,365,500.0	1,951,035,094.4	148,330,405.6	92.9
Унаа хоолны хөнгөлөлт	917,101,600.0	854,009,874.0	63,091,726.0	93.1
Гэрээт ажлын хөлс	12,747,200.0	6,653,220.0	6,093,980.0	52.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,552,032,500.0	1,541,394,163.2	10,638,336.8	99.3
Тэтгэврийн даатгал	1,009,200,000.0	1,118,650,302.6	(109,450,302.6)	110.8
Тэтгэмжийн даатгал	134,950,600.0	107,048,312.4	27,902,287.6	79.3
ҮОМШӨ-ний даатгал	109,323,900.0	82,431,208.0	26,892,692.0	75.4
Ажилгүйдлийн даатгал	27,141,800.0	23,560,899.3	3,580,900.7	86.8
Эрүүл мэндийн даатгал	271,416,200.0	209,703,440.9	61,712,759.1	77.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,460,779,200.0	1,397,232,669.6	63,546,530.4	95.6
Гэрэл, цахилгаан	257,868,100.0	270,280,846.4	(12,412,746.4)	104.8
Түлш, халаалт	728,420,100.0	685,476,973.1	42,943,126.9	94.1
Цэвэр, бохир ус	136,710,700.0	107,471,558.6	29,239,141.4	78.6
Байрны түрээс	337,780,300.0	334,003,291.5	3,777,008.5	98.9
Хангамж, бараа материалын зардал	547,579,300.0	539,292,318.7	8,286,981.3	98.5
Бичиг хэрэг	123,818,200.0	128,875,808.3	(5,057,608.3)	104.1
Тээвэр, шатахуун	155,700,800.0	160,699,204.4	(4,998,404.4)	103.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	164,745,100.0	127,450,740.6	37,294,359.4	77.4
Ном, хэвлэл	200,000.0	324,900.0	(124,900.0)	162.4
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,246,600.0	5,019,772.0	226,828.0	95.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	97,868,600.0	116,921,893.4	(19,053,293.4)	119.5
Нормативт зардал	647,012,200.0	604,473,130.0	42,539,070.0	93.4
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,030,800.0	8,050,963.0	979,837.0	89.2
Хоол, хүнс	583,331,700.0	544,843,349.0	38,488,351.0	93.4
Нормын хувцас, зөөлөн эдлэл	54,649,700.0	51,578,818.0	3,070,882.0	94.4
Эд хогшил, урсгал засварын зардал	236,214,100.0	225,901,022.0	10,313,078.0	95.6
Багаж, техник, хэрэгсэл	131,490,900.0	103,019,948.0	28,470,952.0	78.4
Урсгал засвар	104,723,200.0	122,881,074.0	(18,157,874.0)	117.3
Томилолт, зочны зардал	72,823,300.0	68,636,211.5	4,187,088.5	94.2
Дотоод албан томилолт	72,823,300.0	68,636,211.5	4,187,088.5	94.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,182,059,500.0	1,110,108,523.4	71,950,976.6	93.9





Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,006,304,600.0	971,123,475.5	35,181,124.5	96.5
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	63,463,700.0	39,915,570.0	23,548,130.0	62.9
Даатгалын үйлчилгээ	53,992,500.0	52,966,022.0	1,026,478.0	98.1
Тээврийн хэрэгслийн татвар	10,365,100.0	8,759,818.0	1,605,282.0	84.5
Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,347,800.0	1,080,000.0	267,800.0	80.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	26,202,300.0	23,212,525.2	2,989,774.8	88.6
Газрын төлбөр	5,080,300.0	3,598,575.0	1,481,725.0	70.8
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,403,200.0	3,817,540.6	1,585,659.4	70.6
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,900,000.0	5,634,997.0	4,265,003.0	56.9
Бараа үйлчилгээний бусад зардал	20,414,700.0	23,104,541.0	(2,689,841.0)	113.2
Бараа үйлчилгээний бусад зардал	7,782,000.0	10,490,411.0	(2,708,411.0)	134.8
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,632,700.0	12,614,130.0	18,570.0	99.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	791,333,900.0	752,215,723.4	39,118,176.6	95.1
Бусад урсгал шилжүүлэг	791,333,900.0	752,215,723.4	39,118,176.6	95.1
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	302,933,900.0	282,651,284.0	20,282,616.0	93.3
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	488,400,000.0	469,564,439.4	18,835,560.6	96.1
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	20,736,604,000.0	20,367,411,224.6	369,192,775.4	98.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	19,525,956,300.0	18,776,261,640.6	749,694,659.4	96.2
Улсын төсвөөс санхүүжих	19,525,956,300.0	18,776,261,640.6	749,694,659.4	96.2
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,210,647,700.0	1,591,149,583.9	(380,501,883.9)	131.4
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	126,122,800.0	623,801,510.2	(497,678,710.2)	494.6
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,084,524,900.0	967,348,073.8	117,176,826.2	89.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	8,944,241.4	(8,944,241.4)	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	3,249.0	3,249.0	0.0	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0	0.0	100.0
Төсвийн байгууллага	1.0	1.0	0.0	100.0
Төсвөөс гадуур байгууллага	0.0	0.0	0.0	0.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,624.0	1,624.0	0.0	100.0
Удирдах ажилтан	34.0	34.0	0.0	100.0
Гүйцэтгэх ажилтан	1,305.0	1,305.0	0.0	100.0
Үйлчлэх ажилтан	285.0	285.0	0.0	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,624.0	1,624.0	0.0	100.0
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1,322.0	1,322.0	0.0	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	302.0	302.0	0.0	100.0

